



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баяннуур сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2020/147/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

(Булган аймаг)

2020 он

Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70342580

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716

Аудитор: П.Содном

Утас: 70342495

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	
3		
2	Аудитын тайлан	
5		
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	
11		
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020.02.06 № 33

танай _____ -ны № _____ т

Баяннуур сумын ЗДТГ-ын
ДАРГА Д.ЖИГМЭД ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

006020063

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Баяннуур сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ЗДТГ-ын дарга Д.Жигмэд-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу

Баяннуур сумын ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баяннуур сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.03-аас 2020.02.06-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.06-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймгийн аудитын газар-ын П.Содном хариуцаж хэрэгжүүлэв.

Баяннуур сумын ЗДТГ 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймгийн аудитын газар-т 2020.01.24-ны өдрийн 03/19 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: ЗДТГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь 2016-2020 онд баримтлан ажиллах Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Хөгжлийн хөтөч” хөтөлбөр, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн ИТХ-аас баталсан нийгмийн салбарын хүрээнд хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх, УИХ, Засгийн газраас гаргасан холбогдох эрх зүйн актуудын биелэлтийг зохион байгуулах, сумын эдийн засаг нийгмийн хөгжүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд оршино.

Баяннуур сумын ЗДТГ нь гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

- 2016-2020 онд баримтлан ажиллах Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Хөгжлийн хөтөч” хөтөлбөр
- УИХ, Засгийн газраас гаргасан холбогдох эрх зүйн актуудын биелэлтийг зохион байгуулах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2018 оны 12 сарын 19 өдрийн 382 тоот тогтоолын дагуу
 - Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-
 - “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”
 - “Төрийн үйлчилгээний албан хаагч ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”
 - “Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журмуудыг мөрдлөг болгон ажиллалаа.
- үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баяннуур сумын ЗДТГ санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “СТS” программ хангамж ашигладаг байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 14 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт зардал*-ын 2 хувиар сонгов.

Нийт зардал-г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь - холбоотой юм.

2019 оны *Нийт зардал* 8,233.96 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 8,233.96 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь 2 холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 12 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 6 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 8 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	4,833.70	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	438.40	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
Дүн		5	5,272.10	

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар ЗДТГ тайлант онд 400,0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 749,0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 187 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого
төгрөг/

/мянган

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны орлого	400,0	749,0	349,0	187
Нийт дүн	400	749	349	187

ЗДТГ-ын үнэдсэн үйл ажиллагааны орлого 400,0 мянган төгрөгөөр давсан /тасарсан/ нь ТГ-ын харьяа зочид буудал засварлаж буудлын үнийг нэмсэн үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн байна.

Нийт зардлын 297391,7 мянган төгрөгийг улсын/орон нутгийн төсвөөс, 296065,1 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 577,6 мянган төгрөгийг туслах

үйл ажиллагааны орлогоос, 749,0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан товч тайлбарлах. /

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан товч тайлбарлах. /ЗДТГ-ын буудлыг засвар үйлчилгээ хийж 1900,0 төгрөгөөр зарцуулсан

Хөрөнгө оруулалтын 11390,0 төсөл, арга хэмжээнд 11390,0 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 11390,0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 306660,0 мянган төгрөг буюу 100 хувьтай байгаа нь үйл ажиллагааны орлоготой холбоотой шалтгаалсан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Баяннуур сумын ЗДТГ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 725,5 мянган төгрөгийн зөрчилд 725,5 төлбөрийн акт тогтоосноос 725,5 мянган төгрөгийг барагдуулсан.

Нийт 3 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийг хэрэгжүүлж, 3 зөвлөмж хэрэгжих шатанд, 0 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй буюу зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

2.8.1 ЗӨВЛӨМЖ ӨГӨХӨӨС БУСАД ХЭЛБЭРЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДАЛ

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Зардлын данстай холбоотой асуудал

Сумын ЗДТГ-ын даргын 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/20 дугаар тушаалаар сумын Засаг дарга Б.Ёндонд үр дүнгийн урамшуулал 438.4 мянган төгрөгийг олгосон нь Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 1.2.1, 2.3 дахь " Энэхүү журмын 2.1 дэх заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухай төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана." гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Энэ нь (Холбогдох батламж мэдэгдэл) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 1.2.1, 2.3 дахь " Энэхүү журмын 2.1 дэх заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-

т заасан тухай төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана." тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоох

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

3.1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Бараа үйлчилгээний бусад зардлаас урсгал засварт 731.5, сургалтын төлбөрт 270.0 мянган төгрөгийг бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Энэ нь (Холбогдох батламж мэдэгдэл) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Зориулалт бус зардалд зарцуулсан байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн төлөвлөлтийг бодитой тооцоо судалгаанд үндэслэн хийж, цаашид зориулалт бус зардал гаргах байх. Зөвлөмж өгөх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр хүргүүлж зөвшөөрч гарын үсэг зурсан

3.2 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

3.2.1 Илрүүлэлт:

Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам 2.4 дэх "Энэ журмын 2.1.1, 2.1.2, дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг зарцуулах ба хохиролд зарцуулагдаагүй үлдэгдлийг сарын хуваариас тооцоолж Засаг даргын нөөцөд бэлэн байршуулсан байна." гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, мөн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс Сургуулийн ойд зориулж 2400.0, Эрүүл мэндийн төвд тоног төхөөрөмж авахад 1150.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", МУ-ын Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 318 дугаар тушаалаар баталсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журмын 2.2. дахь "Засаг даргын нөөц хөрөнгийг дараах байдлаар зарцуулахыг хориглоно", 2.2.1.2 дахь "энэ журмын 2.1.1, 2.1.2 -т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрмөж бэлтгэх, хөрөнгө оруулалтын зардал гаргах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Энэ нь (Холбогдох батламж мэдэгдэл) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар

төлөвлөж, зарцуулах", МУ-ын Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 318 дугаар тушаалаар баталсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журмын 2.2. дахь "Засаг даргын нөөц хөрөнгийг дараах байдлаар зарцуулахыг хориглоно", 2.2.1.2 дахь " энэ журмын 2.1.1,2.1.2 -т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрмөж бэлтгэх, хөрөнгө оруулалтын зардал гаргах" тус тус зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Засаг даргын нөөц хөрөнгө, мөрийн хөтөлбөрийн зардлыг зориулалт бусаар зарцуулах

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зориулалт бус зардал гарч болзошгүй байгааг анхаарч ажиллах, журмыг хэрэгжүүлж зориулалт бус зардал гаргахгүй байх. Зөвлөмж хүргүүлэх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр хүргүүлж зөвшөөрч гарын үсэг зурсан

3.3 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

3.3.1 Илрүүлэлт:

НББ-ийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй бодлогын бичиг баримтгүй байна

НББ-ийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй бодлогын бичиг баримтгүй байна. тус тус зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандартын шаардлага хангаагүй байх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Хууль, стандарт, дүрэм, журамд нийцсэн заавар, аргачлалын дагуу бүртгэл хөтлөх НББ-ийн бодлогын бичиг баримтыг боловсруулан баталуулах. Зөвлөмж хүргүүлэх

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр хүргүүлж зөвшөөрч гарын үсэг зурсан

3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

3.4.1 Илрүүлэлт:

Тайлант онд нэмэгдсэн 282.2 мянган төгрөгийн НДШ-ийн авлага нь санхүүгийн тайлан гарахад харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс үүссэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" тус тус зөрчсөн байна.

3.4.2 Эрсдэл:

Авлага өглөг дутуу тусгасан байх

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайлан гарахад харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулан санхүүгийн тайланд тусгаж, авлага, өглөг үүсгэхгүй байх. Зөвлөмж хүргүүлэх

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр хүргүүлж зөвшөөрч гарын үсэг зурсан

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

П.СОДНОМ